



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

┌ Сургалтанд хамруулах тухай ┐

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.8 дахь заалт, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмын 11.7, 13.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Төсөл хэрэгжүүлэх хэлтсийн дарга П.Түвшинзаяаг 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийг дуустал Америкийн Нэгдсэн Улсад зохион байгуулагдах “Тогтвортой хөгжлийн төлөөх манлайлалын ёс зүй” сэдэвт сургалтанд суралцуулсугай.

2. Төсөл хэрэгжүүлэх хэлтсийн дарга П.Түвшинзаяагын сургалтанд хамрагдах хугацаанд цалингүй чөлөө олгосугай.

3. Гадаад сургалтын тайланг ирснээс хойш 7 хоногийн дотор Даргын зөвлөлд танилцуулахыг төсөл хэрэгжүүлэх хэлтсийн дарга П.Түвшинзаяад үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга / Р.Дүүрэнбаяр /-т даалгасугай.

ДАРГА Х.ЭРДЭНЭБИЛЭГ



1150000114